

Эрүүгийн хэрэг шалган шийдвэрлэх тухай хууль

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль

Хууль сахиулах ажиллагааны тухай хууль

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх цогц тогтолцоо

Эрүүгийн хууль

Шүүхийн шийдвэр чиглэх тухай хууль

Зөрчлийн тухай



Аюулгүй ирээдүйг хойч үедээ өвлүүмнэ.



ЖИЛИЙН ТАЙЛАН 2016 ОН

**ХЭҮТ-ийн УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**
Б.ОЮУНБИЛЭГ

ГИШҮҮД:

КОРЕНЬ АЙНАГУЛ

Казах эмэгтэйчүүдийн
эрхийг хамгаалах
“Арулар” холбооны
тэргүүн

**ЦЭРЭНЖАВЫН
АЛТАНЦЭЦЭГ**

Отгонтэнгэр Их
Сургуулийн Хуульзүйн
Дээд сургуулийн захирал

**АРСҮРЭНГИЙН
АМАРСАНАА**

Бие даасан зөвлөх

**БААСАНЖАВЫН
ОЮУНБИЛЭГ**

Канадын Элчин
Сайдын Яамны жөндөр
хариуцсан мэргэжилтэн

**МАГВАНЫ ХОРОЛСҮРЭН
АНУ-ын Элчин Сайдын
Яамны Улс төрийн
хэлтсийн мэргэжилтэн**

**ГОМБОЖАВЫН
ЦЭРЭННАДМИД**

“Номын амт” ТББ-ын
тэргүүн

**НАМСРАЙН ТУНГАЛАГ
Хуульч**

ХАВДСЭЛЭМИЙН НУРЖАН

Хүмүүнлэгийн ухааны
Их сургуулийн багш,
орчуулагч

**Хяналтын зөвлөлийн
гишүүд:**

Ц. ОЮУН

Эдийн засаг бизнесийн
дээд сургуулийн
Санхүүгийн албаны дэд
захирал

С. ЦЭРЭНПҮРЭВ

“Шүтээн уул” компанийн
Ерөнхий нягтлан бодогч

Н.НАРАНЦЭЦЭГ

Улаанбаатар хотын
эмэгтэйчүүдийн
зөвлөлийн дарга

**ХЭҮТ-ийн Захирал
Д.ЭНХЖАРГАЛ**



АЖЛЫН АЛБА:

П.ЗОЛЗАЯА

Үйлчилгээ хариуцсан
дэд захирал

С.БАЙГАЛМАА

Хөтөлбөрийн менежер

Н.АРВИНТАРИА

Эрх зүйн шинэчлэл
хөтөлбөрийн
зохицуулагч

Г.ТҮВШИНЖАРГАЛ

Сургалт, мэдээлэл арга
зүйн хөтөлбөрийн
зохицуулагч

З.УНДРАХ

Хамгаалах байруудын
сүлжээ хөтөлбөрийн
зохицуулагч

Н.ҮҮРИЙНЦОЛМОН

Гадаад харилцааны
ажилтан

А.МӨНХДЭЛГЭР

Нягтлан бодогч

Ч.ОДОНЧИМЭГ

Хуулийн зөвлөгч

Д.САНЧИР

Хуулийн зөвлөгч

Ц.ДАВААСҮРЭН

Сэтгэл зүйч

С.БАДАМХАНД

Дотоод ажлын
менежер

Б.ДОЛЖИНСҮРЭН

Халамжийн ажилтан

Б.ДАВААСАМБУУ

Жолооч

Эрхэм Танд Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ-ын 2016 оны тайланг толилуулж байгаадаа баяртай байна.

2016 он манай төвийн хувьд амжилт, бүтээлээр дүүрэн жил байлаа.

Бидний олон талт, нотолгоонд суурилсан тууштай нөлөөллийн ажлын үр дүнд 12 жилийн дараа Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль шинэчлэн батлагдаж, хүчирхийлэлд өртсөн хүмүүст хамгаалагдах боломж нэмэгдэж, салбар дундын зохицуулалт шинэ түвшинд гарч байна.

Мөн гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх эрхзүйн цогц орчин бүрдүүлэхийн төлөө ажилласан нөлөөллийн ажлын үр дүнд гэр бүлийн хүчирхийлэл анх удаа гэмт хэрэгт тооцогдох боллоо.

Байгуулагдсан цагаасаа эхлэн 22 жилийн турш бидний санаачлан туршиж, түгээн дэлгэрүүлж ирсэн үйлчилгээний төрлүүд болон Хамтарсан багийн загвар нь шинэчлэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулинд цогц үйлчилгээ үзүүлэх албан ёсны механизм болон хуульчлагдлаа.


Дээр дурдсан амжилт бүхэн эрхэм үйлчлүүлэгч, сайн дурын ажилтнууд, түншлэгчид, санхүүжүүлэгчид Та бүхний хүчин чармайлтын үр дүн гэдгийг онцлон тэмдэглэж, хамт олныхоо нэрийн өмнөөс чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Бидний хамтдаа хийсэн ажил бүхэн бодит үр дүн болж, аюулгүй ирээдүйг бүтээх үйлсэд үнэтэй хувь нэмэр оруулж чадсан гэдгийг Та бүхэн энэ тайлангаас олж харна гэдэгт итгэлтэй байна.

Хүн бүрийн аюулгүй байдал, амар амгалан амьдралын төлөөх Та бидний хамтын ажиллагаа өргөжин тэлэхийн ерөөл өргөө!

Хүндэтгэсэн,

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв

Захирал  Д.Энхжаргал

ХӨТӨЛБӨРҮҮД

Түр хамгаалах байруудын сүлжээ

Хүүхэд хамгаалал

Нутгийн хамт олны хөгжил

Сургалт, мэдээлэл арга зүй

Эрх зүйн шинэчлэл

Чадавхи бэхжүүлэх

БИД

ХҮЧИРХИЙЛЛИЙН ДАВАН ТУУЛАГЧДЫН ЭРХ, ХЭРЭГЦЭЭНД СУУРИЛАН ДАРААХ ҮЙЛЧИЛГЭЭГ МЭРГЭЖЛИЙН ТҮВШИНД, ЦОГЦООР ҮЗҮҮЛДЭГ.

Түр хамгаалан байрлуулах үйлчилгээ

Сэтгэл зүйн зөвлөгөө

Нийгмийн ажлын үйлчилгээ

Хүүхэд хамгааллын үйлчилгээ

Хууль зүйн зөвлөгөө, эрх зүйн тусалцаа

Холбон зуучлах үйлчилгээ

Итгэлийн утасны үйлчилгээ

ҮНДСЭН ЗОРИЛГО

Хүн бүрийн аюулгүй, халдашгүй, хараат бус байх эрхийг хангах болон хохирогчийг хамгаалах үр дүнтэй тогтолцоог бий болгоход нөлөөлнө.



Монгол Улсад анх удаа эмэгтэйчүүд, хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй гэр бүлийн хүчирхийлэл, бэлгийн хүчирхийллийг эцэс болгох, хохирогчийг хамгаалах зорилгоор байгуулагдсан анхны **Төрийн бус байгууллага**.



Хүчирхийллийн эсрэг үндэсний төв нь

ашгийн бус,

аливаа нам, улс төрийн хүчнээс хараат бус,

шашны урсгал чиглэлээс ангид нийгэмд үйлчилдэг ТББ.



ХҮЧИРХИЙЛЛИЙН ЭСРЭГ ҮНДЭСНИЙ ТӨВ
1995 онд байгуулагдсан.

Бид шууд үйлчилгээ, бодлогын нөлөөллийг хослуулан ажилладаг.

11 Үндэсний хэмжээнд салбар

2 Хамгаалах байр

1 Нэг цэгийн үйлчилгээний төв

6 Хөтөлбөр

1 сургалт, зөвлөх үйлчилгээний төв



БИД

Хүн бүрийн эрхэм чанар, аюулгүй, халдашгүй, хэнээс ч хараат бус байх жам ёсны эрхийг хангахын төлөө

22 ДАХЬ ЖИЛДЭЭ

тууштай ажиллаж байна.



Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль 12 жилийн дараа шинэчлэгдэн батлагдлаа. Бид уг хуулийг батлуулахын төлөө зүтгэсэн байгууллага, хувь хүмүүсийн хүчин чармайлтыг нэгтгэн, олон талт нөлөөллийн ажлыг үндэсний түвшинд зохицуулж ажилласан.

Бидний 22 жилийн нөлөөллийн ажлын үр дүнд гэр бүлийн хүчирхийллийг анх удаа гэмт хэрэгт тооцох боллоо.

Баянхонгор аймаг дахь салбар нь аймгийнхаа Засаг даргын Тамгын газартай хамтран орон нутгийн засаг захиргаа болон ТББ-ын хосолсон менежменттэй Нэг цэгийн үйлчилгээний төвийн анхны загварыг байгуулж, түршиж эхэллээ.

Монгол Улсын хэмжээнд ажиллаж байгаа Нэг цэгийн үйлчилгээний төв, Түр хамгаалах байрны ажилтнуудыг чадавхижуулах цуврал сургалт зохион байгуулж, түншлэл, хамтын ажиллагааны сүлжээг үүсгэн хөгжүүлж эхэллээ.



ЦОГЦ ҮЙЛЧИЛГЭЭ

Бид үйлчилгээ үзүүлэх явцад илэрсэн аливаа хийдэл, цоорхой, гажуудлыг арилгах, даван туулагчид ээлтэй үйлчилгээ, үр дүнтэй хамгаалалтыг бий болгохын тулд нотолгоонд суурилан нөлөөллийн ажлыг амжилттай хийдэг.



Бид үйлчилгээ үзүүлэх явцдаа төрийн үйлчилгээ үзүүлэх цогц загварыг бий болгож, нөлөөлөн ажиллаж байна.



АНУ-ын Төрийн Департамент болон АНУ-ын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэх зорилгоор нийслэл болон хөдөө орон нутгийн нийт 17 мэргэжилтний бүрэлдэхүүнтэй АНУ-ын Аляска мужийн туршлага судлах ажлын аялалыг зохион байгууллаа.



Foundation Dufrensne & Gauthier сангийн дэмжлэгтэйгээр практикт суурилан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг нөхөн барагдуулах арга зүйг боловсруулан үйлчилгээнд нэвтрүүлж эхэллээ.



Америкийн Элчин Сайдын Яамны дэмжлэгтэйгээр анх удаа Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвүүдийг нэгтгэн “Аюулгүй байдлын хамгаалалтын үйлчилгээ: Хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулж, хамтын ажиллагааны сүлжээг бий болгон чадавхижуулж байна




Монгол Улсад анх удаа төр, төрийн бус байгууллага хамтран “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийг хосолсон менежментээр ажиллуулж эхэллээ. Япон Улсын Засгийн Газрын буцалтгүй тусламж “Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах хөтөлбөр”-ийн дэмжлэгтэйгээр манай төвийн Баянхонгор аймаг дахь салбар нь аймгийнхаа Засаг Даргын Тамгын Газартай хамтран гэр бүлийн хүчирхийллийн даван туулагчид үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвийг байгууллаа.



СУРГАЛТ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Бид 2016 онд гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн даван туулагчид шууд үйлчилгээ үзүүлдэг 596 мэргэжилтний чадавхийг бэхжүүлээ.

- Анх удаа Хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудын чадавхийг бэхжүүлэх зорилгоор олон улсын туршлага, онол, практикийг хослуулсан цогц сургалтыг зохион байгуулж, арга зүйгээр хангалаа. Сургалтыг АНУ-ын эксперт Катерина Тепас, Мишел ДэВитт нар чиглүүлэн ажилласан. Сургалтад шууд үйлчилгээ үзүүлдэг нийслэл болон орон нутгийн 25 мэргэжилтэн хамрагдсан.
- АНУ-ын экспертийн “Хүчирхийллийн хохирогч, даван туулагчдад үйлчилгээ үзүүлэх чадавхийг бэхжүүлэх нь” сургалтыг Хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төв ажиллаж буй нийслэл болон баруун, зүүн, төвийн бүсэд үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүллээ. Сургалтад шууд үйлчилгээ үзүүлдэг нийт 106 мэргэжилтэн хамрагдаж олон улсын жишигт нийцсэн, эрхэд суурилсан үйлчилгээ үзүүлэх мэргэжилтнүүдийн баг бүрдэн ажиллаж байна.
- Манай төв нь МОНФЕМНЕТ, SASA! Активистуудын сүлжээтэй хамтран “Эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нь” сургалтыг Төв болон Баянхонгор аймгийн шүүх, прокурор, цагдаа, эрүүл мэнд, боловсрол, халамжийн болон төрийн захиргааны байгууллагуудын мэргэжилтнүүдэд зохион байгууллаа. Сургалтад нийт 85 мэргэжилтэн хамрагдаж, охид, эмэгтэйчүүдийн эсрэг хүчирхийллийг бууруулах жин дарах хүчийг нэмсээр байна.
- Төрийн анхан шатны нэгж дээр ажиллаж буй хамтрсан баг (засаг дарга, нийгмийн ажилтан, цагдаа, эмч, боловсролын нийгмийн ажилтан, халамжийн нийгмийн ажилтан)-ийн 380 мэргэжилтний чадавхийг бэхжүүлээ.
- Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян
- Бид 20 жил тасралтгүй жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аянг зохион байгуулж байна.
- 2016 оны 16 хоногийн аянд төр болон төрийн бус 30 гаруй байгууллага нэгдэн “Хүчирхийлэлд ҮГҮЙ гэж хэлье!” уриан дор зохион байгууллаа.
- Аяны хүрээнд төрөөс Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх хуулийн шинэчилсэн найруулгыг батлахыг шаардлаа.
- Энэ жил анх удаа Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам санаачлан тус аянд нэгдэж, хамтран зохион байгуулсан нь төр уг асуудалд анхаарлаа хандуулж байгаагийн илрэл юм.



ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА



Meeting on Multi-Sectoral Services to Respond to Gender-Based Violence against Women and Girls in Asia and the Pacific 21-23 November 2016, Bangkok, THAILAND

“Охид, эмэгтэйчүүдийн эсрэг жэндэрт суурилсан хүчирхийлэлд салбар дундын үйлчилгээг бэхжүүлэх” сэдэвт Ази, Номхон далайн бүсийн хуралд 10 орны 100 гаруй хүн оролцлоо.

Нийгмийн хамгаалал, хууль зүй, санхүү төсөв, эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд болон төрийн бус байгууллагууд хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөлдсөн энэ хуралд тус төвийн захирал Д.Энхжаргал оролцлоо.




Олон улсын “Everywomen everywhere coalition” ТББ-ын гэр бүлийн хүчирхийллийн асуудал хариуцсан гишүүн байгууллага боллоо. Уг сүлжээ нь дэлхий нийтээс охид, эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах олон улсын тунхаг гаргах зорилготой юм.

Азийн Хамгаалах байрны сүлжээнээс Сингапур улсад зохион байгуулсан “Хамгаалах байрны хүртээмжтэй үйлчилгээ” чуулганд тус төвийн хоёр ажилтан оролцлоо.

Чуулганд 11 орны 27 байгууллагын 50 төлөөлөгч оролцож Ази дахь гэр бүлийн хүчирхийллийг бууруулах үр дүнтэй, шинэ стратегиуд, гэр бүлийн хүчирхийллийг даван туулагчдын хэрэгцээнд нийцсэн үйлчилгээг хүргэх арга зүй зэргийг хэлэлцлээ.




ТООН МЭДЭЭЛЭЛ




2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТОВЧООН

НИЙТ ОРЛОГО - 568,844,434.40Т



НИЙТ ЗАРДАЛ - 560,169,201.40Т



Бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан байгууллага, хамт олон, хувь хүмүүст БАЯРЛАЛАА.



НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ХҮН АМЫН САН

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулах нөлөөллийн ажилд аргагүй, санхүүгийн дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

АНУ-ЫН ТӨРИЙН ДЕПАРТМЕНТ БОЛОН АНУ-ЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

Хамгаалах байр, Нэг цэгийн үйлчилгээний төвийн ажилтнуудыг чадавхижуулах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА .

ЯПОН УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ “ӨВСНИЙ ҮНДЭС - ХҮНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ХӨТӨЛБӨР”

Баянхонгор аймаг дахь “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн бүтээн байгуулалтын ажилд бүрэн дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

КАНАД УЛСЫН ЭЛЧИН САЙДЫН ЯАМ

Жендэрт суурилсан хүчирхийллээс сэргийлэхэд олон нийтийн оролцоог бий болгох, шинэчлэн батлагдсан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг сурталчилахад дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

FOUNDATION DUFRENSNE & GAUTHIER

Хамгаалах байранд байрлаж байгаа хүүхэд, эмэгтэйчүүдэд зориулсан сэтгэлзүйн болон нөхөн сэргээх үйлчилгээг 2010 оноос хойш тасралтгүй дэмжиж байгаад БАЯРЛАЛАА.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ний түр байрлуулан асрамжлах үйлчилгээг гэрээлэн дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

ТӨВ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

Нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу “Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ”-ний түр байрлуулан асрамжлах үйлчилгээг гэрээлэн дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

МОНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН САН

Бодит кейсээр дамжуулан Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг батлуулах нөлөөллийн ажилд дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

МОНГОЛ ДАХЬ ОЛОН УЛСЫН ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН НИЙГЭМЛЭГ

Хамгаалах байрны гал тогооны өрөөг тохижуулахад дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

HOLT INTERNATIONAL CHILDREN'S SERVICE

Хамгаалах байраар үйлчлүүлсэн даван туулагч 54 хүүхдүүдийг 18 нас хүртэл суурь боловсрол эзэмших эрхийг ханган дэмжлэг үзүүлж байгаад БАЯРЛАЛАА.

“ГАЦУУРТ” ХХК

Хамгаалах байрны өдөр тутмын хүнсний ногоог тасралтгүй хангаж байгаад БАЯРЛАЛАА.

“АРИУН-ХӨГЖИЛ ТРЕЙД” ХХК

Хамгаалах байрны өдөр тутмын ариун цэврийн хэрэгслийг тасралтгүй хангаж байгаад БАЯРЛАЛАА.

“МОНГОЛИАН СТАР ДИСТРИБЬУШИН” ХХК

Хамгаалах байрны өдөр тутмын ариун цэврийн хэрэгслийг тасралтгүй хангаж байгаад БАЯРЛАЛАА.

“ТАВАН БОГД” ХХК

Хамгаалах байраар үйлчлүүлж буй даван туулагч хүүхдүүдийн боловсролыг дэмжин хичээлийг хэрэгслээр хангаж байгаад БАЯРЛАЛАА.

GERMANY ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ НИЙГЭМЛЭГ

Хамгаалах байрны гал тогооны хэрэгсэл хандивлан дэмжлэг үзүүлсэнд БАЯРЛАЛАА.

Бидний үйл ажиллагааг дэмжин хамтран ажилласан байгууллага, хамт олонд баярлалаа.

А.Анударь
Д.Амараа
Б.Ариунчимэг
Ж.Ариунаа
М.Амирлангуй
Н.Арвинтариа
Б.Батцэцэг
Л.Батцэцэг
Л.Бодамцэцэг
Т.Баялаг
Ц.Баттуяа
Н.Должин
Б.Зояа
П.Золзаяа
Д.Мягмарсүрэн
У.Наранцэцэг
Б.Оюундарь
Д.Отгонцэцэг
М.Одгэрэл
н.Очгэрэл
н.Оюунбилэг
Г.Самбуу
Ж.Соёлмаа
Ш.Саранхөхөө
З.Ундрах
Х.Хандсүрэн
М.Цасчихэр
А.Энхжин
Г.Энхжаргал

Аюулгүй ирээдүйг хайр үедээ өвлүүлнэ.



Хүчирхийллийн эсрэг үндэсний төв



Хамгаалах байр



Орон нутаг дахь салбар



Нэг цэгийн үйлчилгээний төв

ONLINE Like 10.922 150% Өсөлтийн хувь

Та манай төвөөс гаргасан шторк, анимейшнтэй дараах линкээр орж танилцана уу.

<https://www.youtube.com/channel/UCVduDvpPOXhh8FOskahcqGA>

ХАЯГ: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6-р хороо, Бага тойруу 40-р байр 03, 06 тоот

Утас/Факс:

+976-70119949

Зөвлөгөө өгөх утас:

+976-96490505

И-мэйл хаяг:

mongolcav@mongol.net

Вэб сайт:

www.safefuture.mn

www.facebook.com

Хүчирхийллийн эсрэг үндэсний төв ТББ/
National center against violence Mongolia

Шуудангийн хайрцаг:

Чингэлтэй 46, Улаанбаатар